



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 17 өдөр Дугаар 18

Хэрлэн сум

XVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 92,3 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1.Монгол Улсын Шадар сайд, улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшингийн баталсан "Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам"-ыг гишүүдэд танилцуулахыг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

2.2020 оны 03 дугаар сарын 14-ны өдөр Улсын Онцгой комиссоос аймгийн Засаг дарга нарт ирүүлсэн 97 дугаар албан бичгийн дагуу 20,000 ширхэг амны хаалт нөөцлөх тухай хэлэлцэхийг газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Монгол Улсын Шадар сайд, улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшингийн баталсан "Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам"-ыг аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрээр зарцуулах,

2.Аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар хурлаар шийдвэрлэсэн "Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зарцуулах журам"-ыг хүчингүй болгохыг.


Нэг. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбатад:


1.1. "Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам"-ыг мөрдөж ажиллах, сумын хүн амын тоогоор амны хаалт нөөцлөхийг бүх сумын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлж үүрэгжүүлэхийг,

1.2. Аж ахуй нэгж байгууллагуудын дарга нарт алба хаагч нарын тоогоор 3 ээлжийн амны хаалт нөөцөлж бэлэн байдлыг хангах тухай албан бичгээр хүргүүлэхийг,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаад:

- 2.1. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газрын алба хаагч нарын бүрэлдэхүүнтэй аймгийн нөөц бүрдүүлэх амны хаалт оёх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллахыг,
- 2.2. Тусгаарлах, ажиглах байрны бэлэн байдал хангасан тухай мэдээллийг аймгийн Онцгой комиссын 19 дүгээр хуралдаанд танилцуулахыг,
- 2.3. Иргэдийг тусгаарласан үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газарт хянуулж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА